

**ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ХҮНСНИЙ  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХИ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Жавхлан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун нарын нэр бүхий 16 гишүүн 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, тариалахыг хориглож, импортлож байгаа хүнсний бүтээгдэхүүний найрлагад тодорхой хязгаарлалтыг тавьснаар Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг ханган хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих таатай орчин бүрдэнэ гэж үзэн хууль санаачлагчид нь энэхүү хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг, А.Сүхбат, С.Жавхлан, Ц.Гарамжав нар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг, Ц.Гарамжав нар хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийх, хувь хэмжээг тогтоох хүчин чадал бүхий лаборатори, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хувиргасан амьд организмын талаар иргэдэд системтэй боловсрол олгох, сурталчлан таниулах талаар бодитой ажлыг мэргэжлийн байгууллагууд зохион байгуулах, Улсын Их Хурлын гишүүн С.Жавхлан төслийн гадаад үг, нэр томъёог Монгол хэлэнд хөрвүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих асуудал дээр анхаарах зэрэг саналуудыг гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж

ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

**Ц.ГАРАМЖАВ**